



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АВТО ЗАМЫН САЛБАРЫН ДҮРЭМ

2022-02-18

АГУУЛГА

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ	2
Нэг. Нийтлэг Үндэслэл	2
1.1 Зорилго	2
1.2 Зорилт	2
1.3 Баримтлах зарчим	2
1.4 Хамрах хүрээ	2
1.5 Дүрэм боловсруулах үндэслэл	2
Хоёр. Танилцуулга	3
Гурав. Удирдлага зохион байгуулалт	3
Дөрөв. Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх	4
Тав. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах	4
Зургаа. Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх	5
Долоо. Оролцогч талуудын үүрэг	6
Найм. Дүрмийн хяналт, хариуцлага	12
ХАВСРАЛТ	13

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг Үндэслэл

1.1 Зорилго

Энэхүү дүрмийн зорилго нь авто замын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Зорилт

Авто замын салбарын хөгжлийн бүх төсөл, хөтөлбөрүүд, аж ахуйн нэгж байгууллагууд болзошгүй гамшиг, нөлөөллийг нь даван туулах чадвартай байх, авто замын аюулгүй найдвартай ажиллагааг хангахад оршино.

1.3 Баримтлах зарчим

Энэхүү дүрмийг хэрэгжүүлэхдээ Гамшгаас хамгаалах тухай хууль, Авто замын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар, MNS ISO 31000:2011, MNS ISO 31010:2016, MNS ISO 22320:2020, MNS ISO 22301:2020 стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.4 Хамрах хүрээ

Энэ дүрэм нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд авто замын салбарын төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах салбарын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх үед энэхүү дүрмийн хавсралтад заасны дагуу уг үйл ажиллагааг зохицуулах шуурхай ажиллагаанд саад учруулахгүйгээр холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангана.

1.5 Дүрэм боловсруулах үндэслэл

“Гамшгаас хамгаалах тухай” хуульд улсын хэмжээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл” байгуулах, уг зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батлах тухай заалтууд тусгагдсан бөгөөд 2020 оны 5-р сарын 14-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр дээр дурдсан зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл

гаргах, эрх зүйн баримт бичгүүдтэй нийцүүлэн шинээр дүрэм боловсруулахаар зохицуулсан. “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд Зам Тээврийн Хөгжлийн Сайд Гамшгаас хамгаалах улсын албаны дарга байхаар заасан бөгөөд тус албаны үндсэн чиг үүрэгт салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх, гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах зэрэг үүргүүд орсон байдаг.

Хоёр. Танилцуулга

- 2.1.** Тус дүрмийн хамрах цар хүрээнд заасны дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд авто замын салбарын оролцогчдыг уялдуулан зохион байгуулах зорилготой “Гамшгийн эрсдэлийг бууруулах автозамын салбарын төлөвлөгөө” нь салбарын хэмжээнд мөрдөх төлөвлөгөөний жишиг болно.
- 2.2.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.4-т “гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг гэж тодорхойлсныг энэ дүрэм баримтална. Дүрэмд ашиглагдах гамшгийн эрсдэлтэй холбоотой бусад нэр томъёог ГХТ хуульд зааснаар ойлгоно.
- 2.3.** Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 327 дугаар тогтоолд заасан “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт”-ийг баримтлан аливаа аюултай болон гамшигт үзэгдэл нь нэр бүхий 17 төрлийн Гамшгийн эрсдэл мөн эсэхийг тогтооно.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

- 3.1** “Гамшгаас хамгаалах авто замын улсын албаны удирдлагын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг, онцгой байдлын үед болон замын бэлэн байдлын мэдээ, мэдээлэл дамжуулах журам”-ын дагуу авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах төрийн байгууллага авто замын салбарын улсын албаны штабыг зохион байгуулж ажиллана. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт гарах бүрд уг штабыг шинэчлэн байгуулна. /Хавсралт № 1/
- 3.2** Нийслэлийн авто зам хариуцсан төрийн байгууллага нь Нийслэлийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллана.
- 3.3** Салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон төрийн бус байгууллагууд Шадар сайдын 2017 оны 75-р тушаалын дагуу мэргэжлийн ангийг байгуулж ажиллана. /Хавсралт № 2/
- 3.4** Аж ахуйн нэгжүүдийн гамшгаас хамгаалах Мэргэжлийн анги /МА/-г тухайн байгууллагын дарга/захирал нь тэргүүлнэ.
- 3.5** Гамшгаас хамгаалах МА нь байнгын бэлэн байдалд ба дараах чиг үүрэгтэй ажиллана.
 - 3.5.1** Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн гамшгийн эрсдэлийн судалгаа болон үнэлгээ, байгууллагын эмзэг байдал, чадавхын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, мэдээ мэдээллээр хангахад хамтран ажиллана.

- 3.5.2 Гамшгийн эрсдэлийг үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан байгууллагын гамшгаас хамгаалах *ерөнхий болон нарийвчилсан төлөвлөгөөг* боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, биелэлтийг эргэн тайлагнана.
- 3.5.3 МА-г мэргэшүүлэх, ажилтан албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулна.
- 3.5.4 Холбогдох журам, заавар зөвлөмжүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх, ажилчдадаа сурталчлах, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.5.5 Гамшгийн үед гамшигт өртсөн хэсгийг аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. Үүнд: зарлан мэдээлэл дамжуулах, хохирол хэрэгцээний үнэлгээ хийх, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, гамшгаас хамгаалах багийг хуралдуулж, шуурхай штаб, бүлэг томилох, мэдээ мэдээлэл цуглуулах, дамжуулах, ар тал хангалтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг хэн хэзээ, хэрхэн зохион байгуулах ажлуудыг тодорхойлсон байна.
- 3.5.6 Гамшгийн сургамжид үндэслэн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлнэ.
- 3.5.7 Оролцогч талуудын хамтын ажиллагааг хангаж ажиллах, харилцан мэдээ мэдээллээр шуурхай хангах бүхий л арга хэмжээ авч ажиллана.
- 3.6 "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 51.2 заалтын дагуу холбогдох зардлыг гаргаж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна.
- 3.7 Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхээр дайчлагдсан тохиолдолд аж ахуйн нэгж нь дайчлагдсан хүн хүч, техник хэрэгсэл, барилга байгууламжийн мэдээ, гарсан зардлын тайлан тооцоог тухайн шатны Засаг даргын Тамгын газарт танилцуулж, нөхөн олговор орон нутгийн төсвөөс гаргуулна.

Дөрөв. Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх

- 4.1 Салбарын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хяналтыг салбарын төрийн байгууллага хэрэгжүүлнэ.
- 4.2 Гамшгаас хамгаалах гадаад хяналтыг төсөл хэрэгжүүлэгч, захиалагч, санхүүжүүлж буй байгууллага болон салбарыг аж ахуй нэгж сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж болох ба гамшгийн бэлэн байдал гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төсөв, зарцуулалт, гамшгийн эрсдэлийн сангийн хяналт, гамшгийн эрсдэлийн удирдлагын чадавхын үнэлгээ зэргийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж болно.
- 4.3 Гамшгаас хамгаалах дотоод хяналтыг салбарын төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүд дотооддоо хэрэгжүүлэх ба хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн акт, стандартын хүрээнд хийж болно.

Тав. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах

- 5.1 Гамшгаас хамгаалах сургалтыг салбарын хэмжээнд Гамшгийн тухай хуулийн 13.4-д заасан шаардлагад нийцүүлэн тодорхой давтамжтай явуулна.

- 5.2 Сургалт сурталчилгааг төрийн ба төрийн бус байгууллагууд, салбарын аж ахуй нэгжүүд өөрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулна.
- 5.3 Гамшгийн жишиг эрсдэлийн үнэлгээ нь Монголын авто замчдын холбоо ТББ тухайн асуудлыг хариуцсан ажилтанд байх ба ажил гүйцэтгэх гэрээ, засвар арчлалтын гэрээ хийсэн байгууллагын хүсэлтээр танилцуулна.
- 5.4 Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг ханган ажиллана.
- 5.5 Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн шийдвэрүүд гарахад салбарын хэмжээнд зарлан мэдэгдэх схемийг боловсруулж ажиллах ба салбарын хэмжээнд нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангана.
- 5.6 Салбарын төрийн ба төрийн бус байгууллагууд, салбарын аж ахуй нэгжүүд харьяа онцгой байдлын байгууллагаар хянуулж, баталгаажуулсан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг ил тод байлгана.
- 5.7 Салбарын төрийн ба төрийн бус байгууллагууд, салбарын аж ахуй нэгжүүд байгууллагын доторх холбоо харилцааны жагсаалтын загвар гарган ажиллах ба байгууллагын салбар болон төсөл бүрд батлан мөрдүүлнэ.
- 5.8 Салбарын төрийн ба төрийн бус байгууллагууд, салбарын аж ахуй нэгжүүд гамшгийн үеийн мэдээлэл дамжуулах бүдүүвчийг гарган бэлэн байдлыг ханган ажиллана.

Зургаа. Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх

- 6.1 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулж, улсын нэгдсэн мэдээлэлд оруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, “Авто замын салбарын гамшгийн мэдээллийн сан”-г бүрдүүлэх ажлыг салбарын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хэрэгжүүлнэ.
- 6.2 “Авто замын салбарын нөөцийн мэдээллийн сан”-г төрийн бус байгууллага хэрэгжүүлнэ.
- 6.3 Мэдээллийн сангийн загвар нь хэрэглэгчид мэдээллийг системтэйгээр удирдан зохион байгуулах, тогтсон бичвэр, хэл, нэршил, кодчилал, томьёолсон тэмдэг ашиглаж хялбар байдлаар гамшиг, ослын нөхцөл байдлын зураглал боловсруулах, үр дүнг шуурхай тайлагнах, тайлан мэдээ, шийдвэр гаргалтад тусгах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр зохион байгуулагдсан байна.
- 6.4 Авто замын салбарын гамшгийн мэдээллийн систем нь хэрэглэгч интернэт болон дотоод сүлжээ холбогдсон аль ч төхөөрөмжийг ашиглан гамшгийн нөхцөл байдлыг хаанаас ч шууд бүртгэх, зураглах боломжийг бүрдүүлэх, төв орон нутгийн анги, салбарууд дотооддоо болон бусад байгууллагуудтай нэгдсэн загвараар мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.5 Авто зам, замын байгууламжийн бүртгэлийг хөтлөх, бүртгэл-мэдээллийн цахим сан байгуулах журмын дагуу авто замын тухайн байдлыг “одын ангиллаар” болон өнгөний ялгарлаар тодорхойлсон байна.

Долоо. Оролцогч талуудын үүрэг

7.1. Төрийн байгууллага нь дараах үүрэг хүлээнэ:

7.1.1. Гамшгийн өмнөх үед:

- а/ “Зам, тээврийн хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Цаг уур, орчны шинжилгээний газрын хамтран ажиллах санамж бичиг”-т тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- б/ Ирээдүйд цаг агаарын аюултай үзэгдэлд өртөх эмзэг байдлыг бууруулах зорилгоор “уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” арга замыг авто замын бодлогын баримт бичигт оруулж, хэрэгжүүлж ажиллана.
- в/ Гамшгийн мэдээллийн сантай болох, хөгжүүлэх, бусад сангуудтай мэдээ мэдээллийг харилцан солилцох боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сангийн баяжилт, өгөгдлийн чанарт хяналт тавих ажлуудыг зохион байгуулна.
- г/ Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаанд бүс нутгийн гамшигт өртөх эрсдэлийн судалгааг хийлгүүлж байна.
- д/ Харьяа байгууллагуудаараа дамжуулан авто зам, замын байгууламжийн эмзэг байдлын судалгааг гаргах, шаардлагатай засвар арчлалтын хөрөнгийг тусгаж ажиллана.
- е/ Авто замын барилга угсралтын ажлын гэрээнд “онцгой үйл явдал”-ыг тодорхой тусгаж байх, онцгой үйл явдлын үед гүйцэтгэгчийн гэрээг цуцлахгүй байх, сул зогссон хугацаагаар гэрээг сунгах арга хэмжээ авч ажиллана.
- ё/ Авто замын хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9-10.1.12 заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- ж/ Гамшигт өртөж болзошгүй авто зам, замын байгууламжийн судалгааг гаргана.
- з/ Харьяа албад, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай багаж хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- и/ Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тохиолдлуудыг бүртгэх дүн шинжилгээ хийх, дасан зохицох стратеги боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- й/ Ирээдүйн үерийн өсөлтийг удирдах (ус зайлуулах системийг сайжруулах г.м), уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох оновчтой нөхцөлийг бүрдүүлэхэд байгууллага, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулна.
- к/ Хоёрдогч хөнөөл болох магадлалтай гал түймрээс сэргийлэх, цахилгааны шугамыг засварлах, бэхлэх, шалгана.
- л/ Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх талаар хүн ам, ажилтан албан хаагчдад ухуулга сурталчилгаа хийнэ.
- м/ “Цар тахлаас урьдчилан, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-г хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллана.

- н/ Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэм үйл ажиллагаа нь нөлөөлж, доголдуулахаар салбарын аж ахуйн нэгж, байгууллага, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдийг мэдээллээр хангах, онцгой байдлын асуудал эрхэлсэн, мэргэжлийн болон зохих шатны байгууллагатай холбох, нэгдсэн зохион байгуулалтад ороход дэмжлэг үзүүлнэ.
- о/ Барилга объектын галын аюулгүй байдлыг хангуулах, гал унтраах багаж хэрэгслийн хангалт, гал түймрээс урьдчилан сэргийлэхэд салбарын чадавхыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

7.1.2. Гамшгийн үед:

- а/ Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.
- б/ Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.
- в/ Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.
- г/ Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэнэ.
- д/ Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ.
- е/ Шуурхай бүлгийн удирдагч онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.
- ё/ Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.
- ж/ Баригдаж байгаа болон хариуцсан зам, замын барилга байгууламж, барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй байдлыг хангаж гамшгийн эрсдэлээс болж учрах хохирлын хэмжээг багасгаж, хамгаалалтад авна.
- з/ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд нь түр цугларах аюулгүйн талбайтай байна.

7.1.3. Гамшгийн дараах үед:

- а/ Сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Шуурхай штабыг төрийн байгууллага нь зохион байгуулна.
- б/ Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаа, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан сэргээн босгох үйл ажиллагааг Шуурхай штаб удирдан зохион байгуулна.

- в/ Шуурхай штаб нь үүссэн нөхцөл байдал, хохирлын болон хэрэгцээ, шаардлагын үнэлгээ хийж, хүн ам, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хэвийн нөхцөлийг хангахад чиглэсэн сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.
- г/ Гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн зам, замын байгууламжид үзлэг шалгалт хийх, хохирлыг үнэлнэ.
- д/ Зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулна.
- е/ Хэрэв цацраг үүсгүүр, химийн бодисын тархалт гарвал тусгай цэвэрлэгээний баг томилж ажиллуулах ажлыг зохион байгуулна.
- ё/ Засварын зардлын тооцоо, эвдрэлийн хэмжээ, зэрэглэлээр зам, замын байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах ажлыг зохион байгуулна.
- ж/ Сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийг дайчилна.
- з/ Гамшгийн дараах хоёрдогч аюул-халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж бохирдсон нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал халдваргүйжлийг холбогдох байгууллагаар хийлгүүлнэ.
- и/ Эрүүл мэнд, хэв журам сахиулах ажиллагааг эхлүүлнэ.
- й/ Онцгой комисс, Онцгой байдлын алба, дээд шатны байгууллагыг мэдээллээр хангана.
- л/ Гамшигт өртсөн бүс нутгийн зам, замын байгууламжийн нөхцөл байдал, хаагдсан замын чиглэлүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.
- м/ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгаль орчинд ээлтэй, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулна.
- н/ Сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг авто замын зураг төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулна.

7.2. Төрийн бус байгууллага нь дараа үүрэг хүлээнэ:

7.2.1. Гамшгийн өмнөх үед:

- а/ Салбарын нөөцийн мэдээллийн цахим сан байгуулах, хөгжүүлэх, бусад сангуудтай мэдээ мэдээллийг харилцан солилцох боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сангийн баяжилт, өгөгдлийн чанарт хяналт тавих ажлуудыг зохион байгуулна.
- б/ Барилга угсралтын ажлын Захиалагч, Гүйцэтгэгчийн гэрээнд “Онцгой үйл явдал” зүйлийг нэмэлтээр тусгуулах, гамшгийн үеийн гүйцэтгэгчийн эрсдэлийг бууруулах, хамгаалахад чиглэгдсэн заалтуудыг тусгуулахад бүх талын арга хэмжээ авч ажиллана.
- в/ Гамшгаас хамгаалах нөөцийн мэдээллийн санг хөтлөх, тогтмол шинэчлэлт хийнэ.

- г/ Нөөцийн бүртгэл, мэдээллийг төрийн байгууллагад шуурхай гаргаж өгнө.
- д/ Салбарын түвшинд сэрэмжлүүлэг мэдээллийг түгээнэ.
- е/ Гамшгаас хамгаалах мэдлэг олгох, мэргэшүүлэх сургалтыг салбарын түвшинд зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- ё/ Цахим сүлжээ болон бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан цаг агаарын “Аюултай”, “Онц аюултай” үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээг салбарын түвшинд түгээнэ.
- ж/ Цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, холбогдох хуулийг салбарын мэдээллийн сайтаар дамжуулан салбартаа сурталчилна.
- з/ Холбогдох нөөцийн мэдээллийг бүртгэх, шинэчлэх, төрийн байгууллагад шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

7.2.2. Гамшгийн үед:

- а/ Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.
- б/ Авто замын тухай хуулийн 12.1.7 зүйл зааснаар байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний туслалцаа авах ажлыг зохион байгуулна.

7.2.3. Гамшгийн дараах үед:

- а/ Эрүүл Мэндийн Яам, Цагдаагийн Ерөнхий Газар болон Улсын Онцгой Комиссоос гаргасан аливаа шийдвэрийг салбартаа шуурхай мэдээлэх ажлыг зохион байгуулна.
- б/ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн, сайн дурын хэсэг, бүлэг, нөхөрлөлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- в/ Авто замын гамшгийн мэдээллийн санд бүртгэл хийнэ.

7.3. Аж ахуйн нэгж нь дараах үүрэг хүлээнэ:

7.3.1. Гамшгийн өмнөх үед:

- а/ Хүн хүч, тоног төхөөрөмжийн нөөцийн мэдээллийг холбогдох төрийн бус байгууллагад гаргаж өгнө.
- б/ Ажилтан, ажиллагсад, ажил үйлчилгээ, материал тоног төхөөрөмжийг зохих даатгалд хамруулна.
- в/ Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулж, мөрдөж ажиллана.
- г/ “Авто зам, замын байгууламжийн бүртгэлийг хөтлөх, бүртгэл-мэдээллийн цахим сан байгуулах журам”-ыг мөрдөж, “Авто зам, замын байгууламжийн бүртгэлийн

- цахим сан”-нд өөрийн хэрэгжүүлсэн төслийн өгөгдлийг оруулах арга хэмээ авч ажиллана.
- д/ Барилга байгууламжийн бат бэх, тогтвортой байдлыг хангах бүх талын арга хэмжээ авах, үзлэг шалгалтыг тогтмол хийнэ.
 - е/ Барилга байгууламжид: орц, гарц, аврах шатыг тодорхой тусгасан; үйлдвэрлэлийн талбайд: цугларах цэгийн байрлал, галын цэг г.м мэдээлэл бүхий схем байрлуулах, ажилтан албан хаагчдад таниулна.
 - ё/ Гамшгийн эрсдэлийн үед аврах, хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах орон тооны бус шуурхай дэд багийг байгуулж, сургаж дадлагажуулна.
 - ж/ Ажилтан албан хаагчдад гамшгийн үед авах арга хэмжээ, өөрийгөө болон бусдыг аврах мэдлэг олгох сургалтад хамруулна.
 - з/ Хээрийн бригад, үйлдвэр, түр барилга байгууламжуудыг төлөвлөх, барихдаа орчны тандалт судалгаа хийж, үерт автахгүй байршлыг сонгож байгуулна.
 - и/ Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч барилга байгууламж, түр барилга байгууламжуудын шаардлагатай хэсгүүдэд үерийн хамгаалалт хийнэ.
 - й/ Шатах, дэлбэрэх материалын агуулахууд, барилга байгууламжуудыг үерийн ус үл нэвтрэх материалаар барих, урсахаас урьдчилан сэргийлж бэхэлнэ.
 - к/ Цаг агаарын мэдээ тогтмол авч ажиллана.
 - л/ Үер усны аюул болох тухай сэрэмжлүүлгийг үйлдвэрлэлийн бүх шатны ажилтан албан хаагчдад зарлан мэдээлнэ.
 - м/ Авто замын барилга угсралтын ажлын онцгой цэгүүд болох гүүр хоолойн барилга байгууламжийг үерт автахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд: Материал, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх, үерийн усыг өнгөрөөх төлөвлөгөө боловсруулах г.м
 - н/ Барилга байгууламж, үйлдвэр мөн бусад хөлдөлтөд өртөж болзошгүй эмзэг цэгүүдийн дулааны шугам сүлжээнд байнгын үзлэг шалгалтыг хийж, хөлдөлтөөс хамгаалах арга хэмжээ авна.
 - о/ Алслагдмал болон хээрийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтан албан хаагчдыг улирлын нөхцөлд тохиромжтой хувийн хамгаалах хэрэгслүүдээр хангана.
 - п/ Үйлдвэрлэлийн болон ажлын талбай, карьеруудад ажиллаж байгаа ажилтан албан хаагчид, хээрийн бригадуудыг найдвартай харилцаа холбоогоор хангах, ашиглалтын байдалд тогтмол хяналт тавина.
 - р/ Барилга объектын аюулгүй гарц, схем зураглалыг байр, давхар бүрд байрлуулах, ажилтан албан хаагчдад таниулна.
 - с/ “Цар тахлаас урьдчилан, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 12.2, 13.2 дугаар зүйлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах, дотоодын хяналт тавьж ажиллана.
 - т/ Тэсэрч дэлбэрэх шатамхай бодисын хэрэглээ болон зарцуулалтад нь тогтмол хяналт тавих, бүртгэл хөтөлнө.

- у/ Тэсэрч дэлбэрэх шатамхай бодис хадгалалт, ашиглалтын /түлш, битум, тэсэлгээний материалын агуулах, ахуйн хэрэглээний газ г.м/ тусгаарлалтыг хийж тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, харуул хамгаалалт гаргана.
- ү/ Тэсэрч дэлбэрэх шатамхай бодисын хадгалалт, тээвэрлэлтийг дүрмийн дагуу гүйцэтгэх, цэнэглэсэн болон хоосон баллоныг зориулалтын агуулахад хадгална.
- ф/ Тэсэрч дэлбэрэх шатамхай бодисын ашиглалтын аюулгүй ажиллагааны журмыг мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавина.
- х/ Асфальтбетон зэрэг материалын үйлдвэр, заводуудын угсралтын ажлуудыг ханган нийлүүлэгчийн гарын авлагын дагуу хийж гүйцэтгэх, мэргэшсэн, туршлагатай бригад, багаар гүйцэтгүүлнэ.
- ц/ Гамшгийн үед цугларах цэгийг байгуулна.
- ч/ Шаардлагатай багаж хэрэгслээр нөөцийг нэмэгдүүлнэ.

7.3.2. Гамшгийн үед:

- а/ Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ.
- б/ Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай үзүүлэх үүрэгтэй.
- в/ Баригдаж байгаа болон хариуцсан зам, замын барилга байгууламж, барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй байдлыг хангаж гамшгийн эрсдэлээс болж учрах хохирлын хэмжээг багасгаж, хамгаалалтад авна.

7.3.3. Гамшгийн дараах үед:

- а/ Гамшигт өртсөн бол дотоодын Шуурхай багийг зохион байгуулах, үүссэн нөхцөл байдлын талаар анхдагч мэдээллийг харьяа орон нутгийн шуурхай штабт өгнө.
- б/ Гамшигт өртсөн ажилтан албан хаагчдыг яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулна.
- в/ Дотооддоо эрүүл мэнд, хэв журам сахиулах ажиллагааг эхлүүлнэ.
- г/ Эвдэрсэн барилга байгууламжийн эвдрэл гэмтлийн зэрэглэлийг тогтоох, хохирлын хэмжээг үнэлэх ажилд төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- д/ Химийн хорт болон аюултай бодис, цацраг, цацраг идэвхт бодисын алдагдлын улмаас үүссэн хохирол, нөхцөл байдлын талаар үнэн зөв мэдээллээр хангана. Энэ тохиолдолд шуурхай штабаас томилогдсон тусгай цэвэрлэгээний бүлэгт хор уршгийг арилгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.
- е/ Мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
- ё/ Нэрвэгдсэн зам, замын байгууламж, барилга байгууламжийн хог хаягдлыг зайлуулах, сэргээн засварлах, гарцыг чөлөөлнө.
- ж/ Барилга, түр байгууламжийн онц чухал объектыг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.
- з/ Нэмэлт хүчээр дайчлагдах бол үүргээ хэрэгжүүлнэ.

и/ Сургамжид үндэслэн барилга байгууламжийн эмзэг цэгүүдийг тодорхойлон хамгаалалтын арга хэмжээг авах

Найм. Дүрмийн хяналт, хариуцлага

- 8.1** Төрийн байгууллага нь авто замын салбарын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавьж, биелүүлээгүй этгээдэд холбогдох хуулийн хүрээнд хариуцлага тооцож ажиллана.
- 8.2** Төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох хууль эрх зүйн актад гарах аливаа шинэчлэлт, Төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс гарах саналд үндэслэн энэхүү дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрд нь хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 8.3** Төрийн бус байгууллага тус дүрэмд сайжруулалт хийхэд шаардлагатай ажилд зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлж, дүрмийг таниулан сурталчлах, салбарын оролцогчдод хүртээмжтэй хүргэх ажлыг хариуцна.
- 8.4** Аж ахуйн нэгж нь тус дүрэмд заасан ажлын хэрэгжилтэд дотоодын хяналт тавьж, нөөцийн мэдээллийг тогтсон хугацаанд илгээх, шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь холбогдох байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

--oOo--

ХАВСРАЛТ

Авто замын салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах
үйл ажиллагааны дүрмийн 1 дүгээр хавсралт

Хавсралт №1

**Гамшгаас хамгаалах Авто замын салбарын улсын албаны штабын жишиг бүтэц,
зохион байгуулалт**

